Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТСИЙН ЖУУЛЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЖУУЛЧНЫ МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ ТӨВҮҮД ХАРИУЦСАН МЕНЕЖЕР ТУЛГА-ЫН МЭРГЭНИЙ
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1: “Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэндийг хөгжүүлж, үйлчилгээний стандартыг олон улсын жишигт нийцүүлнэ.”, “Жуулчдад зориулсан соёлын болон тусгай сонирхлын аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, аяллын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно.” зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ: МУЗГҮАХ-3.3.5.8, НЗДҮАХ-3.4.1** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1** Аялал жуулчлалын мэдээлэл сурталчилгааны төвүүдийн үйл ажиллагааг үргэлжлүүлнэ. | Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийн тоо | 6 | 6 | Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг 7 байршилд буюу “Төв шуудан”, жанжин Д.Сүхбаатарын талбай, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал, ХБНГУ-ын Фрайбург хотод байрлах Монголын соёл, аялал жуулчлал, мэдээлэл, худалдааны төв болон “Тэрэлж Монгол Олле”, “Хонхор тосгон Монгол Олле”, “Сөүлийн гудамж Монгол Олле” төвүүдийг тогтмол болон улирлын чанартай ажиллуулан хагас жилийн байдлаар 4756 гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. Жуулчны мэдээллийн төвүүдийн байршлыг гадаад, дотоодын жуулчдад ойлгомжтой хайлт үүсгэх үүднээс “Google map” сайт дээр байршуулан ажилласан. | 01-12 | 100 |
| 2 | **Арга хэмжээ 1.2.** Аялал жуулчлалын мэдээлэл | Жуулчны мэдээлэл сурталчил | 6 | 7 | Үндэсний онцлог бүхий жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд байршлын судалгааг хийсэн бөгөөд жуулчид хамгийн ихээр зорчдог 4 газар /Улсын их дэлгүүр, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сурталчилгааны төвийн тоог нэмэгдүүлнэ. | гааны төвийн тоо | | | Гандантэгчэнлин хийд, Шинэ Улаанбаатар, баруун терминал, Баянзүрх авто воксал, УБТЗ/-ын судалгааг гаргаж ажилласан. Судалгааны хүрээнд Гандантэгчэнлин хийд болон Улаанбаатар төмөр замын Аялал жуулчлалын төвтэй уулзалт хийсэн боловч нийслэлийн хөрөнгө оруулалтын 2025 оны төсвөөс хасагдсан. Тиймээс Урт цагааны гудамжийг жуулчны гудамж болгон тохижуулах ажил нийслэлээс хийгдэж байгаатай холбогдуулан Жуулчны мэдээлэл сурталчилгааны төв шинээр байгуулах саналыг холбогдох газарт хүргүүлэн, зураг төсөлд оруулсан. | 01-12 | 100 |
| 3 | **Арга хэмжээ 1.3.** Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвөөр дамжуулан гадаад дотоодын иргэд жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл түгээх | Мэдээлэл зөвлөгөө өгсөн хүний тоо | 10741 | 4500 | Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/56 дугаар захирамжийн дагуу төсөвтэйгөөр Улаанбаатар хотод Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг 3 байршилд ажиллуулж байна. Үүнд: Д.Сүхбаатарын талбай, Төв шуудан, Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын нэгдүгээр давхарт тус тус тогтмол ажиллаж байна. Мөн Монгол Оллэ төрийн бус байгууллага, Герман улсын Фрайбург хотын аялал жуулчлалын элч нартай хамтран нийт мэдээлэл сурталчилгааны төвийн үйл ажиллагааг тогтмол болон улирлын чанартай явуулж байгаа бөгөөд хагас жилийн байдлаар 4756 гадаад, дотоодын иргэнд жуулчдад мэдээ мэдээлэл зөвлөгөө өгч үйлчилгээ үзүүлсэн байна. | 01-12 | 100 |
| 4 | **Арга хэмжээ 1.4** Улаанбаатар хотын аяллын “Сити тур” төслийг үргэлжлүүлэх | Хотын аялалд хамрагдсан хүний тоо | 7,380 | 1000 | Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, гадаад дотоодын жуулчдын хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор “Сити тур” төслийг хэрэгжүүлэхээр газрын даргын А/14 дугаартай тушаалыг батлуулсан. Эхний хагас жилийн байдлаар 766 хүнийг аялалд хамруулан ажилласан. | 01-12 | 90 |
| **Зорилт 2: “Албан бизнес болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.” зорилтын хэрэгжүүлэх арга хэмжээ: НЗДҮАХ-3.4.2** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Арга хэмжээ 2.1** Оюутан цагдаа хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | 90 | - | 62 | Жуулчдын аюулгүй байдлын хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/117 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монголын Оюутны холбоотой хамтран "Оюутан цагдаа" хөтөлбөрийн төлөвлөгөөг гаргаж, оюутнуудын бүртгэл мэдээллийг хийсэн бөгөөд сонгон шалгаруулалтыг 2025 оны 6 дугаар сарын 03,04-ний өдрүүдэд хийж, нийт 62 оюутныг бүртгэн авсан. 2025 оны 6 дугаар сарын 05-ны өдөр холбогдох байгууллагуудтай хамтран сургалт, арга зүйгээр хангаж, 6 дугаар сарын 10-ны өдрөөс "Оюутан цагдаа" хөтөлбөрийг эхлүүлээд байна. | 04-09 | 70 |
| 2 | **Арга хэмжээ 2.2** Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээ, цагийн хуваарь, байршлын судалгааг нэгтгэх, мэдээллийн санг үүсгэж, сурталчлах | 90 | - | 62 | Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдээр дамжуулан жуулчдад олгодог нийслэл болон орон нутгийн аялал жуулчлалын мэдээллийн санг 40 гаруй төрлөөр бүрдүүлж, улирал бүр тогтмол шинэчлэн ажиллаж байна. Үүнд:<br>• Зочид буудал, амралт, сувиллын газруудын мэдээлэл<br>• Зах худалдааны төвүүдийн мэдээлэл<br>• Түүхэн дурсгалт барилга байгууламж, хөшөө дурсгалын тайлбар<br>• Тур оператор, аялал жуулчлалын байгууллагуудын мэдээлэл<br>• Музей үзмэрийн газруудын мэдээллүүд<br>• Нийтийн тээвэр, хот хоорондын зорчигч тээврийн мэдээлэл<br>• Ресторан зоогийн газар, кофе шопын мэдээлэл<br>• Цагдаа, эмнэлэг, элчин сайдын яамнуудын мэдээлэл<br>• 21 аймгуудын амралтын газар, жуулчны бааз, ресторанны мэдээлэл<br>• Чингис хаан олон улсын нисэх буудлын мэдээлэл | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Дотоод аялал<br>• Цахим мэдээлэл<br>• Машин түрээсийн үйлчилгээ гэх мэт.<br>Мөн Нийслэлийн Аялал жуулчлалын газрын www.visitulaanbaatar.net веб сайтад мэдээ мэдээлэл цэс дотор зорин очих газар гэх шинэ цэс үүсгэн Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүний мэдээллийг оруулж, баяжуулалт хийн ажилласан. | | |
| 3 | **Арга хэмжээ: 2.3** Жуулчдын гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор урьдчилан сэргийлэх мэдээлэл түгээх | 100% | | 50% | Тус газраас гадаад хэл дээр хэвлүүлдэг Улаанбаатар хотын газрын зураг, Улаанбаатар сэтгүүл дээр яаралтай үед холбогдох тусламжийн дугааруудыг шинэчлэн байршуулсан бөгөөд тараах материалуудыг Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдээр дамжуулан гадаад дотоодын жуулчдад түгээж байна. | 01-12 | 100 |
| 4 | **Арга хэмжээ 2.4** Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээний тайланг тухай бүр тайлагнах | 100% | | 50% | Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээний тайланг сар, улирал бүр тайлагнаж ажиллаж байна. | 01-12 | 100 |
| **Зорилт.3 “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 3.1.** visitulaanbaatar.net цахим сайтад Жуулчдад зориулсан мэдээ мэдээллийг шинэчлэх, нэмэлт мэдээллийг тусгах | Шийдвэрлэлт-ийн хувиар | 50% | 50% | Жуулчны мэдээллийн төвийн ажилтнуудад байгууллагын цахим хаягт мэдээ мэдээлэл бэлтгэх хуваарь гаргаж 1 сард нэг мэдээг бэлтгүүлэн ажилласан. | 01-12 | 100 |
| 2 | **Арга хэмжээ 3.2.** Албан хэрэг хөтлөлтийг заавар, дүрэм, журам, стандартын дагуу зохион бүрдүүлэн хөтлөх, ирсэн | Шийдвэрлэлт-ийн хувиар | 50% | 50% | Тайлант хугацаанд нийт 14 иргэн, аж ахуй нэгж байгууллагаас албан бичиг ирсэн бөгөөд тухай бүр судалж, шийдвэрлэсэн. | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэх | | | | | | |
| 3 | **Арга хэмжээ 3.3.** “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2024 оны архивын материалыг хүлээлгэн өгнө. | Шийдвэрлэлтийн хувиар | 100% | 100% | “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2025 оны 1 дүгээр улиралд 2024 оны архивын баримт бичгийг хүлээлгэн өгсөн. | 01-12 | 100 |
| 4 | **Арга хэмжээ 3.4.** Иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл хүсэлт, санал гомдлыг түргэн шуурхай хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэх | Санал хүсэлтийн тоо | 20% | 80% | Тайлант хугацаанд өргөдөл, гомдол ирээгүй болно. | 01-12 | 100 |
| 5 | **Арга хэмжээ 3.5.** Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг явуулах. | Хэрэгжилтийн хувиар | 50% | 50% | Байгууллагын өмч хамгаалах зөвлөл 2025 оны 4 дүгээр сард хуралдаж хэрэглэх боломжгүй болсон актлах эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж, Нийслэлийн Өмчийн харилцааны газар руу актлуулах тухай албан бичгийг хүргүүлж ажилласан. | 01-12 | 100 |
| 6 | **Арга хэмжээ 3.6.** Жуулчдын сэтгэл ханамжийн судалгааг эвент арга хэмжээ, цахим хэлбэрээр болон мэдээллийн тээвэр дамжуулан авч нэгтгэн, мэргэжилтнүүдэд мэдээлэх | Хэрэгжилтийн хувиар | 50% | 50% | Тайлант хугацаанд зохион байгуулсан арга хэмжээн дээр сэтгэл ханамжийн судалгааг гаргаагүй болно. | 01-12 | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | **Арга хэмжээ 3.7** Жуулчдын гэмт хэрэг, зөрчилд өртсөн болон холбогдсон судалгаа гаргах | Хэрэгжил тийн хувиар | 50% | 50% | Нийслэлийн Цагдаагийн удирдах газраас 2023 оноос 2025 оны эхний улирлын байдлаар жуулчдын гэмт хэрэгт хохирсон, холбогдон шалгагдаж байгаа судалгааг авч дүн шинжилгээ хийж ажилласан. Энэ хүрээнд "Хамтдаа шийдвэрлэе" арга хэмжээний төлөвлөгөөнд Жуулчдын аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд Дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүд дээр гадаад хэлний мэдлэгтэй албан хаагчдыг тогтмол ажиллуулах /жуулчидтай харилцах нэгж, тасаг бий болгох саналыг тусгаж батлуулсан. | 01-12 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1. Байгууллагын ёс зүй дэд хорооноос зохион байгуулах сургалтад хамрагдах | Хамрагдсан сургалтын тоо | - | 1 | Ёс зүйн дэд хорооноос 2025 оны эхний хагас жилд зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" сургалтад хамрагдсан. | 01-12 | 100 |
| 2 | Арга хэмжээ 2. Хувь хүний хөгжлийн болон төрийн албан хаагчийн ур чадварын сургалтуудад хамрагдах | Хамрагдсан сургалтын тоо | - | 4 | Жуулчдын сэтгэл зүй, соёлын ялгааны тухай, мөн Удирдлагын академиас зохион байгуулсан цахим сургалтад тус тус хамрагдсан. | 01-12 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**
ЖУУЛЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
МЭДЭЭЛЛИЙН ТӨВҮҮД ХАРИУЦСАН МЕНЕЖЕР

/ Т.МЭРГЭН / 2025.06.05

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР ХУУДАС

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Үүрэг даалгавар1.** Өндөржүүлсэн бэлэн байдлын хүрээнд агаар бохирдуулагч судалгаа гаргах ажлын хэсэгт ажиллах | Газрын дарга | Ажлын хэсэгт орсон тоо | 1 | 2025 оны 01 дүгээр сарын 18,19-ний өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн 28,29-р хорооны нутаг дэвсгэрт агаар бохирдуулагч судалгаа гаргах ажлын хэсэгт тухайн хорооны хэсгийн ахлагчийн хамт 221 айлаар орж ажилласан. | 01 | 01 |
| 2 | **Үүрэг даалгавар 2.** “Чингис хаан” олон улсын нисэх буудлын “НУБИА”-с зохион байгуулж байгаа сургалтад хамрагдах | Газрын дарга | Сургалтад хамрагдсан тоо | 1 | Нисэх буудлын буудлын аюулгүй байдал, Иргэний нисэхийн аюулгүй байдал зэрэг хуулийн талаар болон Онцгой нөхцлийн төлөвлөгөө боловсруулах сургалтанд 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр сургалтад хамрагдсан. | 02 | 02 |
| 3 | **Үүрэг даалгавар 3.** “Нарны баяр-Наурызын баяр” арга хэмжээний зохион байгуулалтад орж ажиллах | Газрын дарга | Хэрэгжилтийн хувиар | 100% | “Нарны баяр-Наурызын баяр” арга хэмжээний хүрээнд төв тайзны урд хэсэгт иргэдийг хэт ойртуулахгүй байхаар ажилласан. | 03 | 03 |
| 4 | **Үүрэг даалгавар 4.** Олон улсын “Узбек” хоолны өдөрлөг арга хэмжээний хүрээнд | Газрын дарга | Ажилласан тоо | 7 | Олон улсын “Узбек” хоолны өдөрлөг арга хэмжээний хүрээнд Жанжин Д.Сүхбаатарын талбайд байгаа 50х80 хэмжээтэй асарын | 04 | 04 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | харуул хамгаалалт хариуцах | | | | аюулгүй байдлыг хангаж “Бүргэд хамгаалалт” ХХК-тай гэрээ байгуулан 7 шөнө хүлээлгэн өгч ажилласан. | | |
| 5 | **Үүрэг даалгавар 5.** “Францын соёлын өдөр” арга хэмжээний хүрээнд харуул хамгаалалт болон сайн дурын ажилтан хариуцах | Газрын дарга | Хэрэгжилтийн хувиар | 100% | “Францын соёлын өдөр” арга хэмжээний хүрээнд “Талын мэргэн”, “Бүргэд хамгаалалт” ххк нартай “Аюулгүй байдлын гэрээ” байгуулж 2025 оны 04 сарын 26,27-ны өдрүүдэд ажилласан. | 04 | 04 |
| 6 | **Үүрэг даалгавар 6.** Мэдээллийн төвийн ажилтнуудад хурал зохион байгуулах | Хэлтсийн дарга | Хурал зохион байгуулсан тоо | 1 | Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн Жуулчны мэдээллийн төвийн 4 ажилтанд 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр хурал зохион байгуулсан. | 05 | 05 |
| 7 | **Үүрэг даалгавар 7.** “Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах арга хэмжээ”-ний зохион байгуулалтад орж ажиллах | Газрын дарга | Хэрэгжилтийн хувиар | 100% | “Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах арга хэмжээ”-ний хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 09,10-ны өдрүүдэд ажилласан. | 05 | 05 |
| 8 | **Үүрэг даалгавар 8.** “Травел экспо” арга хэмжээний хүрээнд бэлтгэл ажлыг хангаж ажиллах | Газрын дарга | Хэрэгжилтийн хувиар | 100% | “Травел экспо” арга хэмжээний хүрээнд бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд тайзны бүүт засах болон тараах материалын бэлдэж ажилласан. | 05 | 05 |
| 9 | **Үүрэг даалгавар 9.** “Талын салхи” олон улсын мото фестиваль арга хэмжээний хүрээнд сайн дурын ажилтан хариуцах | Газрын дарга | Хэрэгжилтийн хувиар | 100% | “Талын салхи” олон улсын мото фестиваль арга хэмжээний хүрээнд үйлчилгээний 10 ажилтан хариуцаж 2025 оны 06 дугаар сарын 7,8-ны өдрүүдэд ажилласан. | 06 | 06 |

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

| | | | |
|---|---|---|---|
| МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ | .................................. | / Н.АЛТАНЗАЯА / | 2025.06.10 |
| ЖУУЛЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВҮҮД ХАРИУЦСАН МЕНЕЖЕР | .................................. | /Т.МЭРГЭН / | 2025.06.05 |